

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УЯНГА СУМЫН НУТАГТ ОРШИХ ӨЛТИЙН УУРХАЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-00362

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн:...../Ч. Дамбасүрэн/

Боловсруулсан:

“Аум алт” ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн:...../М. Бямбасүрэн/

2022 он



АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

- 3.1. Агаарын орчны сөрөг нөлөөлөл
- 3.2. Усны чанар, нөөцөд нөлөөлөх байдал
- 3.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл
- 3.4. Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ
ЗОРИЛТ

- 4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
 - 4.1.1. Агаарт чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ
 - 4.1.2. Газрын гадарга, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ
 - 4.1.3. Усан орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ
 - 4.1.4. Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах арга хэмжээ
- 4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт
- 4.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- 4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- 4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- 4.6. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт
- 4.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт
- 4.8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт
- 4.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбрийн биелэлт
- 4.10. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

ТАВ. ДҮГНЭЛТ



Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Уурхайн тоосонцорын ялгаралт, кг.....	13
Хүснэгт 2. Уурхайн усны хэрэглээ.....	13
Хүснэгт 3. Агаарын бохирдлыг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ.....	17
Хүснэгт 4. Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажлууд.....	19
Хүснэгт 5. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажлууд.....	23
Хүснэгт 6. Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах ажлууд.....	24
Хүснэгт 7. Нөхөн сэргээлтийн зардал.....	26
Хүснэгт 8. Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн байршил болон хэмжээ.....	27
Хүснэгт 9. Биологийн нөхөн сэргээлтийн талбайн байршил болон хэмжээ.....	28
Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	38
Хүснэгт 11. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний нөхөн сэргээлтийн цэгүүд.....	38
Хүснэгт 12. Уурхайгаас сард ялгарах ахуйн бохирын тооцоо.....	44
Хүснэгт 13. Хог хаягдлын менежментээр хэрэгжүүлсэн ажил.....	46
Хүснэгт 14. 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын биелэлт.....	47
Хүснэгт 15. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	50
Хүснэгт 16. Агаарын чанарт хийсэн шинжилгээний нэгдсэн дүн.....	50
Хүснэгт 17. 2022 онд усны чанарт хийсэн шинжилгээний нэгдсэн дүн.....	51
Хүснэгт 18. 2022 онд хийгдсэн хөрсний шинжилгээний нэгдсэн дүн.....	52
Хүснэгт 19. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	56
Хүснэгт 20. 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт.....	58



ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн байршил болон ерөнхий байдал	6
Зураг 2. Кемпийн тохижилтын ажил хийгдсэн байдал	20
Зураг 3. ШТС-ийн орчмын түлш асгарсныг цэвэрлэсэн байдал	21
Зураг 4. Яамны дор асгасан шингэн, бохирдсон хөрсийг зайлуулж, шинээр хөрс хучсан байдал	21
Зураг 5. ШТС-ийн түгээх хэсэг болон автоцистern зогсох талбайг хучив	22
Зураг 6. Тунгаах нуурын ерөнхий байдал	23
Зураг 7. Биологийн нөхөн сэргээлт ерөнхий бйадал	25
Зураг 8. Гал унтраах хэрэгсэл	25
Зураг 9. Галын дохиолол суурилуулж	25
Зураг 10. Талбайг тэгшилж буй үйл явц	29
Зураг 11. Шимт хөрсний овоолгоос хөрсийг зөөвөрлөж буй байдал	30
Зураг 12. Шимт хөрсийг талбайд зөөвөрлөн асгаж буй байдал	30
Зураг 13. Талбайд шимт хөрсийг тарааж буй үйл явц	30
Зураг 14. Үрслэгч машиныг талбайд ажиллуулж эхлэв	31
Зураг 15. Биологийн нөхөн сэргээлт хийж буй үйл явц	32
Зураг 16. Нөхөн сэргээлтийн нашаалсан байдал	32
Зураг 17. Нөхөн сэргээлтийн хашаа барих үйл явц	32
Зураг 18. Сэргээлтийн талбайн ургалт а. 2018 он б. 2019 он	33
Зураг 19. Нөхөн сэргээлтийн талбайн ургалт а. 2020 он б. 2021 он	33
Зураг 20. Биологийн нөхөн сэргээлтийн талбайн үзүүлэлт	34
Зураг 21. 2020 оны нөхөн сэргээлт	35
Зураг 22. 2018 оны нөхөн сэргээлт	35
Зураг 23. 2019 оны нөхөн сэргээлт	36
Зураг 24. 2021 оны нөхөн сэргээлт	36
Зураг 25. 2022 оны нөхөн сэргээлт	36
Зураг 26. нөхөн сэргээлтийн усалгаа	37
Зураг 27. Булаг хашаалсан байдал	38
Зураг 28. “ТЭРБУМ мод” тариалалтын ажил	Error! Bookmark not defined.
Зураг 29. Хогийн цэгийг булсаны дараах байдал, шинээр хогийн бункер байрлуулсан байдал	40



Зураг 30. Ажилчдын амрах байр болон кемпийн ггазруудад жижиг хогийн сав байрлуулав	41
Зураг 31. Хог хаягдалыг сумын төвийн хог цэг рүү зөөвөрлөн асгаж буй байдал	41
Зураг 32. Нүхэн жорлон	41
Зураг 33. Хоол хүнсний хаягдал нь гахайн тэжээл болж байгаа нь	42
Зураг 34. Гал тогооноос гарч байгаа хоолны үлдээдлээс бусад хог	42
Зураг 35. Төмрийн хаягдлын зөөн өмнөх талбайг машины зогсоол болгосон байдал	42
Зураг 36. Аюултай хог хаягдлыг түр хадгалах цэг	43
Зураг 37. Тос масло түр хадгалах цэг	43
Зураг 38. Шингэн болон хуурай хог хаягдлын цэг	45
Зураг 39. “Хог хаягдал ба эрүүл мэнд” сэдэвт сургалтын үйл явц	45
Зураг 40. Кемпийнхээ ойр орчмын 50 метр доторх хог хаягдлыг цэвэрлэж буй байдал	45
Зураг 41. Өвөрхангай аймгийн УЦУОШГ-аас уурхай дээр шинжилгээ хийж байгаа байдал	49
Зураг 42. Гал унтраах галын баг	53
Зураг 43. Ариутгал хийж буй процесс	53
Зураг 44. Уул уурхайн аврах ангиас зохион байгуулсан сургалт	54
Зураг 45. Эмийн хангамж болон ажилчдын ковидын шинжилгээ	55
Зураг 46. Цахилгааны монтаж болон аюулгүй байдлыг сайжруулав.	55
Зураг 47. Ажилчдын амрах байр болон нийтээр үйлчлүүлэх газруудад засвар үйлчилгээ хийв.	56



НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: MV-000362 тоот тусгай зөвшөөрөл бүхий Өлтийн бүлэг орд

Байгаль орчны бодлого: “АУМ АЛТ” ХХК-нь уул уурхайн үйлдвэрлэлийг экологи, байгаль орчны тогтвортой байдлын бодлогыг баримтлан үйл ажиллагаа явуулдаг ба доорхи зорилтын дор үйл ажиллагааг явуулдаг.

- Байгаль орчны хамгаалах талаар авч хэрэгжүүлэх арга нь Монгол улсын хууль, тогтоомж стандарт бодлого, зорилтын дор үйл ажиллагаа явуулах
- Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг тогтоох, урьдчилан сэргийлэх, нөлөөллийг багасгах
- Мониторинг хяналт шинжилгээг тогтвортой явуулах
- Байгаль орчны нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж гүйцэтгэх


Төсөл хэрэгжүүлэгч: “АУМ АЛТ” ХХК нь Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт орших Өлт нэртэй MV-000362 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд үйл ажиллагаа явуулж жил бүр нөхөн сэргээлтийн ажиллагааг хийж гүйцэтгэж, аймаг сумын ажлын хэсэгт хүлээлгэн өгч байна.

Тус компанийн MV-000362 тоот тусгай зөвшөөрлийн талбай нь Засгийн газрын 2015 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 289 дүгээр тогтоолоор гол мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн заагаас бүрэн чөлөөлөгдсөн ба 2020 онд Техник эдийн засгийн үндэслэлийн тодотголыг “Майн инженеринг” ХХК-аар гүйцэтгүүлсэн. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголыг “Дөрвөн талст экологи” ХХК хийж, холбогдох хууль тогтоомжийн дагуу баталгаажуулсан. Тус компани 2022 онд холбогдох хууль журмын дагуу Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамаар батлуулж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн, биелэлтийг хүргүүлж байна.

Төслийн байршил. Өлтийн дээд хэсгийн алтны шороон орд нь Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт орших Өлтийн хэсгийн бүлэг ордод хамаарагдана. Тусгай зөвшөөрлийн талбай нь Улаанбаатар хотоос баруун зүгт 420 км, Өвөрхангай аймгийн Арвайхээр хотоос баруун хойд зүгт 95 км, Уянга сумын төвөөс хойд зүгт 35 км зайд байрлана.



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УЯНГА СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ ӨЛТИЙН ДЭЭД ХЭСГИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ



Зураг 1. Төслийн байршил болон ерөнхий байдал



Ажил гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлт

1. Тус компани нь аймгийн мэргэжлийн хяналтын газар, байгаль орчин аялал жуулчлалын газар, сумын байгаль орчны зөвлөл зэрэг байгууллагуудтай хамтран мэргэжлийн хүмүүсийн заавар зөвлөмжийн дагуу нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгч ажиллаж байна.
2. Газар, ус ашигласны төлбөр, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө, хогны төлбөр зэрэг холбогдох төлбөр хураамжуудыг цаг тухайд холбогдох байгууллагад төлж орон нутгийн төсөвт оруулсан.
3. Үйл ажиллагаа явуулж буй талбайд тэмдэг тэмдэглэгээ хийж самбаржуулсан.
4. Ажлын явцад уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5917:2008 стандартыг мөрдөж ажилласан.
5. Ажиллах хүчний 90% хувийг орон нутгийн ажилчдаас бүрдүүлсэн ба орон нутгийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын орлогыг орон нутгийн төсөвт цаг тухайд оруулсан.
6. Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулсан.
7. Байгаль орчны хяналт шинжилгээг мэргэжлийн байгууллагаар тогтмол хийлгэв.
8. Орон нутгийн хөгжлийг дэмжих, нийгэм эдийн засагт компанийн хувь нэмэр оруулах үүднээс хандив, тусламж үзүүлж төгрөгийг зарцуулаад байна.



ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Газар зүйн бүсчлэл. Өлтийн бүлэг орд нь Хангайн нурууны салбар уулсуудын өвөрт, хойд өргөрөгийн 46 градус 48 минут, зүүн уртрагийн 102 градус 19 минутанд, экваторын бүсээс 51625 км-т, хойд талаараа Баянхонгор аймгийн Өлзийн, Эрдэнцогт сум, өөрийн аймгийн Бат-Өлзий, зүүн талаараа Зүүнбаянт-улаан, урд ба баруун талаараа Тарагт, Хайрхан дулаан, Нарийн тээл сумуудтай хиллэдэг. Нутаг дэвсгэрийн нийт талбай 313.0 мяган га ба үүний 28.8 хувийг ой мод эзэлдэг.

Нутгийн хойд цэг Хан баян уулнаас урд цэг Хужиртын Шар мухар хүртэл 70 км, зүүн захын цэг Онттолтын цагаан хөтлөөс Баруун жаргалантын нуруу хүртэл 102 км алслагдсан байдаг. Нутгийн хамгийн өндөр цэг нь далайн түвшинөөс дээш 3147 м өндөрт өргөгдсөн Оньдолтын ам юм.

Хүйсийн Найман нуурын сав нутаг нь тусгай хамгаалалттай газар нутагт хамрагддаг байгалийн дурсгалт газар юм. Шуранганы улаан цохио, Түрэг хааны хөшөө, Арслан хотын туурь, Хар цагаан Уушахай зэрэг түүх соёлын дурсгалт газруудтай. Сумын төвөөс баруун хойш 25 км зайд үзэгсгэлэнт Найман нуур хүрэх замд Шурангын голын эрэг дээр байдаг 28 м өндөр хос тайхар цохио юм.

Цаг уур. Уур амьсгалын төлөв байдал агаарын температурын хувьд ихээхэн ялгаатай эрс тэс олон жилийн дундаж үзүүлэлтээр дулаан 25-30 хэм, Хур тунадас олон жилийн дунджаар жилд 354.5 мм хүрнэ. Газар нутгийн онцлогоос хамаарч аадар бороо орох тохиолдол цөөнгүй бөгөөд зарим тохиолдолд хоногт 46 мм тунадас унана. Дулааны улирлын 62 хоногт хур бороо, 36 хоногт нь цас орно. Энэхүү хур тунадасны горимтой уялдан агаарын чийгшил сард 50-70% байна. Ер нь агаарын чийгшлийн хувьд эл нутаг нь тийм ч хуурай биш.

Салхины дундаж хурд бараг бүх саруудад 4.2-5.2 м/с, салхины хамгийн их хурд 14-20 м/с хүрэх бөгөөд хавар, намрын улиралд хүчтэй салхины үргэлжлэх хугацаа бусад саруудынхаас илүү байдаг ажээ. Жилийн дунджаар авч үзвэл баруун хойд, хойд, зүүн, өмнө зүгийн салхи зонхилох бөгөөд эдгээрийн давтагдал 17.5-22.4 байна. Жилийн аль ч сарыг авч үзсэн баруун ба баруун өмнөд, зүүн зүгийн чиглэлийн салхины давтагдал хамгийн бага буюу 1.6-8.2%-ийн хооронд хэлбэлзэнэ.

Хөрс, ургамал. Уянга орчмын газар нутаг нь хөрс газарзүйн мужлалын хувьд Төв Азийн их мужийн Хангайн мужид багтах бөгөөд энд гол хөндийн нутгийн хүрэн хөрс, хээрийн ба уулын хээрийн хүрэн хөрс тархана. Механик бүрэлдэхүүний хувьд хөнгөн шавранцар хөрс голлон өнгөнөөсөө эхэлж том жижиг сайран чулуу элбэг таарна. Энэ хүрэн хөрс доошилж уулын бэл хормой нам хэсэг рүү шилжих тусам үржил шимт давхарга нь зузаарч ялзмагийн хэмжээ нэмэгдэнэ. Ингээд хүрэн хөрс нь хар хүрэн, зарим хэсэгтээ ялангуяа хойшлох тусам шавранцар хөрстэй бүрдэл байдлаар тархана.

Нутгийн хойд хэсэгт уулын хар шороон хөрс, зүүн хэсгээр нь хээрийн хүрэн хөрс, өмнө захаар нь говийн саарал хөрс, элсэнцэр хөрс тархжээ. Нутгийн хойд хэсэгт хангайн их хөвч, тайга, зүүн хэсгээр хээрийн бүсийн, өмнө хэсгээр говийн ургамал тархжээ. Хангайн гол нуруу ерөнхийдөө баруун хойноос зүүн урагшаа сунаж тогтсон бөгөөд баруун талын Цэцэн уулнаас зүүн талын Дэлгэрхаан уул хүртэл 700км шахам үргэлжилсэн нуруу юм. Энэ нурууны



геологийн бүтцэд боржин чулуу ихээхэн суурь эзлэхийн зэрэгцээ хувирмал занар, элсэн чулуу, хүрмэн чулуу зэрэг чулуулаг элбэг тохиолдоно.

Үнэмлэхүй өндөр дунджаар 3000 м орчим боловч зарим оргил далайн түвшинээс дээш 3500-4000 м хүрнэ. Хангайн гол нурууны оргил нь мөнх цастай Отгонтэнгэр уул 4031 м хүртэл сүндэрлэнэ. Хангайн гол нурууны хяр голдуу хавтгай буюу бөмбөрцөгдүү хэлбэртэй, эртний тэгш өндөрлөгүүдтэй. Тэгш өндөрлөгүүдийн оройгоор намаг, жижиг нуруудтай. Гол нурууны дунд хэсэгт уулын хажуу эгц цавчим, хад чулуу элбэгтэй байдаг. Харин зах тийшээгээ намссаар гадаргын байдал бэсрэг уулын шинжтэй болно.

Амьтны аймаг. Ан амьтдаас буга, бор гөрөөс, шилмүүс, чоно, дорго, үнэг хярс, тарвага, туулай, чандага болон бусал уулархаг ба тал хээрийн бүсийн өвсөн тэжээлтнүүдээс гадна зарим махчин, жижиг мэрэгчид элбэгтэй, нүүдлийн болон байнгын нутагладаг ойн ба нүүдлийн шувууд байдаг.

Хүн амын суурьшил. Бусад нутагтай харьцуулахад хартцангуй нягт, нутгийн оршин суугчид нь мал аж ахуй эрхэлдэг. Сүүлийн жилүүдэд ул уурхайн чиглэлийн үйлдвэрлэл эрхлэгчид нүүдэллэн ирж суурьшсан бөгөөд тэдгээрийн дийлэнхи нь богино хугацааны ашиглалттай жижиг шороон орд ашигласан уурхай тул хүн амын нягтшил улирлын чанартайгаар түр ихсэж байдаг. Эдгээр олон жижиг уурхайнууд нь гол даган байрлаж, усны урсац дагууд хаяа хаяагаа дэрлэн үргэлжилсэн эвдрэл үүсгэсэн. Уул уурхайн олборлолт, баяжуулах үйлдвэрүүд эрчимтэй хөгжиж байгаа ч уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн чиглэл, чанар болон цаашдын суурьшил, аж ахуй эрхлэлт, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж зэрэг олон асуудалд онцгой нөлөө үзүүлэх тал бий.

Эдийн засаг, дэд бүтэц. Ашиглалтын талбайд хамгийн ойрхон суурин газар Уянга сум бөгөөд талбайгаас баруун хойш зүгт байрлана. Уянга сумын төв нь хүн амын нягтшил дунд зэрэг, гол төлөв мал аж ахуй, бага зэрэг газар тариалан, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх ба төвийн эрчим хүчний системд холбогдсон, ШТС болон эмнэлэгн ахуйн үйлчилгээний газруудтай. Сүүлийн үед тус суманд жижиг дунд үйлдвэрүүд, хувиараа цагаан тугалга, вольфрам олборлогчид ихэссэн. Улаанбаатар хот болон бусад газруудтай шууд харилцах тоон системд холбогдсон МЦХ компанийн болон үүрэн телефон утасны операторуудын сүлжээнүүд тавигдсан байдаг. Улаанбаатар хот болон бусад аймаг, сумын төвүүдтэй Өвөрхангай-Улаанбаатар хотын хооронд тавигдсан хатуу хучилттай замаар холбогддог. Талбай хүртэл жилийн аль ч улиралд автомашинаар зорчиж болно. Дэд бүтэц, зам харилцаа сайн хөгжлийн бүс нутаг юм.

Ордын геологийн тогтоцын тухай мэдээлэл. Өлтийн бүлэг орд нь 35 градус хазгай уналтай тектоник эвдрэлд өртсөн, гүний усны түвшин өндөр зэргээс шалтгаалан гидрогеологийн нилээд хүнд нөхцөлтэй ордод тооцогдоно. Гидрогеологийн гол хүндрэлийн доод-дунд юрын уст давхарга учруулж болзошгүй. Ус агуулагч хурдас нь хар шороо, алевролит, хөрзөн чулуу болохоос гадна нүүрсний давхарга ч ус агуулагчид багтана.

Тухайн ордод ус тээгч цогцолбор нь олон тооны цооногоор илэрсэн бөгөөд гүний усны түвшин гадаргуугийн байдлаас хамааран 8.1м (ц-33)-ээс 18м (ц-39)-ийн гүнд байрладаг. Газрын доорхи усны нэвчилт өмнөөс умард руу чиглэлтэй, энэ нь нүүрсний давхаргын уналтай давхцаж байгаа юм. Газрын доорхи ус нь даралтгүй. Хайгуулын 3 цооногийн



шавхалтын үр дүнгээр шүүрэлтийн итгэлцүүр 0.007 м/хоногтой тэнцүү гэж тогтоожээ. Усны эрдэсжилт 0.76-0.98 г/л. Химийн шинжилгээгээр эрдэсжилтийн найрлага нь гидрокарбонат-сульфат-хлорит-магникальцийн эрдэсжилттэй ус гэж тогтоогдсон байна. Газрын доорхи усны тэжээгч эх үүсвэр нь хур тунадасны усны болон хажуугийн чулуулаг дахь уст давхаргын усны шүүрэлт юм. Ордыг ашиглах үед гадаргуугаас 14 м гүн хүртэл хуурай уст давхаргын усны шүүрэлт юм. Үүнээс доош, тухайлбал 30 м-н гүн хүртэл усны шүүрэлт харьцангуй бага, карьерын шавхалтаар явуулж болох юм.

Стратиграфи. Өлтийн ордын районы геологийн тогтоцод дараах стратиграфийн хурдас чулуулгууд багтдаг. Үүнд:

- a. Дээд силурын галт уулын гаралтай хурдас чулуулаг
- b. Доод карбоны настай хурдсын тунамал чулуулаг
- c. Дунд-дээд юрын нүүрс агуулсан тунамал хурдас
- d. Дөрөвдөгчийн хурдас

Гүний чулуулаг. Өлтийн ордын районд девоны настай боржин, пермийн настай боржин гэсэн 2 насны гүний чулуулаг хөгжжээ. Ордын өмнөд тал болох Бага Самант, Самант уулсыг бүрдүүлэгч лейкократ боржинд гнейсжилт ажиглагддаггүй. Гадаргуу арзгар хад цохиотой рельеф үүсгэдэг, хойд буюу Хотгорын хонхор талаас нь доод-дунд девоны настай нүүрс агуулагч тунамал хурдсаар хучигдаж түүний ул суурийн (базальны) зузаалгыг үүсгэдэг. Пермийн настай гүний чулуулаг нь ягаавтар саарал өнгөтэй дунд талстат, биотит-эвэр хуурмагт, шигтгээлэг боржин, хүчиллэг найрлагатай эффузивийн субвулкан биетүүдээс тогтоно.

Тектоник хөдөлгөөн. Тухайн район нь тектоник хөдөлгөөнд аль эртнээс өртөж эхэлсэн бөгөөд одоо цагийг хүртэл идэвхитэй үйлчилж байна. Үүний тод жишээ нь 1957 оны газар хөдлөлтөөр Их богдын гүний хагарлын ихэнхи хэсэг нь дахин сэрсэн явдал юм. Түүнчлэн гүний хагарлуудаас салбарласан буюу тэдгээрийн нөлөөлөлд байдаг хагарал эвдрэлүүд ч сэрсэн байна. Тектоник хагарлуудыг үүссэн цаг үеэр нь неопротерозойн-кембрийн, девоны, шинэхэн үеийн болон 1957 оны газар хөдлөлтөөр сэргэсэн гэж хувааж болно. Ордын баруун талд Их самант уулын урдуур хэсэгт доод карбоны хурдас, мөн юрын хурдас дээгүүр тохрон гулссан байна. Эдгээр нь девоны болон шинэхэн үеийн тектоник идэвхижлийн үр дүнд үүсчээ. Үүнээс гадна сброс свит бүхий тектоник хагарал эвдрэл ордын дундуур ба түүний ойр орчмоор явагдсан байдаг.

Газар доорхи болон газар дээрхи ус

Гадаргын ус. Өлт голын хөндийд 1993-1995 онд хийсэн геологи хайгуулын ажлын тайланд Өлт булгийн ундаргыг 13л/с, 2002 онд Геоэкологийн хүрээлэнгийн эрдэмтэд, судлаачдын багийн боловсруулсан Өлт голын голдиролыг нөхөн сэргээх төслийн хүрээнд хийсэн хээрийн судалгааны хэмжилтээс үзэхэд “Өлт голын усны зонхилох гүн нь голын нийт уртад 0.1-0.25м, урсгалын хурд нийт уртын дагуу 0.2-0.35 м/с, голын эргийн өндөр 0.2-0.5 м, ус нь голын эхэн хэсэгт хайрга чулуун гадарга дээгүүр, адаг орчимдоо хайрга, элсэн гадарга дээгүүр урсдаг гэж тодорхойлсон байна.

2003 онд “Байгаль экологи” ХХК-ний хийсэн БОНБНУ-ний хээрийн судалгааны ажлын явцад урсацыг тооцдог аргачлал, эмпирик томъёог үндэслэн Өлт голын олон жилийн дундаж



урсацын модуль 0.33 л/сек*км², урсацын норм 0.016 м³/сек, урсацын давхраа 10.3 мм байна гэж тогтоож байсан. 2008 онд БОНБНУ нэмэлт тодотголын тайлангийн хээрийн судалгааны явцад Өлт гол уулсын малталтаар гаргасан хаягдал овоолго шороонд дарагдаж, урсацыг хэмжих нэг ч хөндлөн огтлолгүй, ус урсах голдиролгүй болсныг тогтоосон. Өөрөөр хэлбэл Өлт голын хаврын их цасны уснаас тэжээл авах боловч, алт олборлох зорилгоор үйлдвэрийн хэрэгцээнд газар доорхи усыг ашиглах болсоноор усны түвшин доошилж, улмаар Өлт голын хөндийн газрын гадарга эвдрэл, доройтолд ихээр өртөгдсөн байна. Сүүлийн жилүүдэд дэлхийн цаг уурын дулаарал, хуурайшилттай холбоотойгоор жилд унах хур тунадасны хэмжээ багасч, гадаргын урсац эрчимтэй татрах болсон. Нөгөө талаас Өлтийн алтны бүлэг шороон ордыг ашиглаж эхэлсэнээс хойш /1993-2008/ газар доорхи усны түвшин буурч, гадаргын урсац эрс багасч, голын голдирол эвдрэлд орж Өлт гол тасарсан байна

Газар доорхи ус. Өлт орчмын нутаг дэвсгэрт 1993-1995 онд хийсэн геологийн зураглалын үед Өлт булгийн усны химийн найрлагыг гидрокарбонат-кальци-магнийн гэж тогтоосон байна. Энэ үед эрдэсжилт нь 0.31 г/л байжээ.

Геоэкологийн хүрээлэнгээс Өлт голын голдиролыг нөхөн сэргээхтэй холбогдуулан хийсэн судалгааны үед буюу 2002 оны 5 сард усны дээж авч шинжилгээ хийхэд гидрокарбонат-кальци-натрийн найрлагатай, 0.32 г/л эрдэсжилттэй, 4.3 мг-экв/л хатуулагтай байжээ. Дээрхи судалгааны дүнгүүдээс үзэхэд төсөл хэрэгжиж эхэлсэнээс хойш буюу 1993-2002 оны байдлаар Өлт булгийн ус найрлагын хувьд хэвийн байсан байна.

2003 онд Өлт голын ус зарим хэсэгтэй умбуур бодисоор бохирдсон байв. Тухайлбал С₁-2 блокийн орчимд алт угаасан цэврийн нуурын далангийн ёроолоос шүүрч байсан уснаас бороо орж байсан үед дээж авч умбуур бодисыг тодорхойлоход, түүний хэмжээ 94 мг/л болж байв. Энэ хэмжээ нь Өлт гол гадаргын усны цэврийн IV зэргийн буюу бохирдолттой ангилалд багтаж байв.

Өнөөгийн байдлаар Өлт гол урсахаа больсон ба Өлтийн талбай 1993 оноос олборлолтын үйл ажиллагааны явцад үүссэн нуурууд шинжилгээний дүнгээр бохирдолтой байна.



ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Уул уурхайн үйл ажиллагааны явцад олон арван жил уурхайлалт явагдсан бүс нутагт, Өлт голын хөндийд байрлах тул алт олборлох технологийн бүхий л үе шатанд газрын хэвлийн эвдрэл, газрын доорхи усны нөөцийн бохирдол, хомсдол, ургамлан нөмрөгийн өөрчлөлт, хөрсний элэгдэл, эвдрэл, геологийн тогтцын өөрчлөлт, зэрлэг ан амьтдын байршилт, тархалтын өөрчлөлт байгалийн нөөцийн хомсдол, бэлчээрийн талбай багасах, эрчим хүчний хэрэглээ нэмэгдэх, тэрчлэн агаар, ус, хөрсний бохирдол үүсэх, химийн бодисоос үүдэн гарах нөлөөлөл зэрэг сөрөг нөлөөллүүд хамаарна.

Болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт. Хөрс хуулалт, металл олборлолт, овоолго байгуулах зэрэг үйл ажиллагааны явцад их хэмжээний шороо тоос босч агаар мандлыг бохирдуулж байдаг. Үүний зэрэгцээгээр уурхайд хэрэглэгдэж байгаа уулын болон технологийн тээврийн хэрэгслүүд бүгд дотоод шаталтын хөдөлгүүртэй учраас ажиллаж байхад ялгарах утаа, тортог агаар орчны хэсэгчилсэн бохирдолтыг бий болгож байдаг.

Үйлдвэрийн технологийн ажиллагааны явцад их хэмжээний тоос шороо босч салхиар зөөгдөн ойр хавийн ялангуяа салхины давамгайлах чиглэлийн дагуу хөрс ургамлын дарж байгалийн өнгө төрх алдагдуулж болзошгүй. Газрын гадарга, хөрс нь ахуйн хаягдал болон ашиглагдсан шатахуун тослох материалаар бохирдох магадлалтай.

3.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь агаар бохирдуулагч цэгэн эх үүсвэрүүд болох ба автомашины хөдөлгүүрийн шаталтаас үүсэх дутуу хий агаар орчныг хорт хийгээр бохирдуулна. Түлшний эх үүсвэрээс агаарт гарах дэгдэлт нь уурхайн тоног төхөөрөмжийн ажиллагаанаас болон уурхайд ажиллах хүнд механизм болон тээврийн машинуудаас, бусад зөөврийн төхөөрөмжүүдийн ажиллагаанаас үүсэлтэй байна. Олборлолтын үед гарах тоос шороо нь тухайн орчны агаарыг бохирдуулах, улмаар ажилтан, албан хаагчид, болон нутгийн хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Ордын ашиглалтын үндсэн процессүүд болох хөрс хуулах, элс олборлох, хөрсний гадаад болон дотоод овоолго байгуулах, элс баяжуулах зэрэг үйл ажиллагаанаас болон ил уурхайн ухаш, гадаад хөрсний овоолго зэрэг эвдрэлд орсон талбайн гадаргуугаас орчны агаарт тоос босно. Уурхайн эвдрэлд орсон талбайгаас үүсэх тоосжилтын хэмжээг тодорхойлвол:



$$P_0 = S \cdot W_c \cdot Y;$$

P_0 - эвдэрсэн газраас хийссэн шорооны хэмжээ;

S - эвдэрсэн талбайн хэмжээ;

W_c - тоосонцорын хийсэх хувийн тогтмол (эвдэрсэн газрын гадаргаас тоос хийсэх өдрийн салхины хурдыг тооцож гаргасан) жижиг ширхэгтэй тоосонцорын хувьд

$W_c = 1 \cdot 10^{-6} \text{ кг/м}^3 \cdot \text{сек};$

$Y = 0.1$ (уулын жижиг ширхэгт массын коэффициент);

$P = 20000 \text{ м}^2 \cdot 1.0 \cdot 10^{-6} \text{ кг/м}^3 \cdot \text{сек} \cdot 0.1 = 0.002 \text{ кг/сек}$ буюу 7.2 кг/цаг, жилд(өдөрт 10 цаг) үзэхэд 8.6 тн тоосжилт жилд үүсэхээр байна.

Хүснэгт 1. Уурхайн тоосонцорын ялгаралт, кг

№	Тоосонцорын ялгаралт, кг				
	1 сек	1цаг	1 хоног	1 сар	1 жил
1	0,002	7.2	72	2,160	8,640

3.2. Төслийн үйл ажиллагаанаас усны орчинд үзүүлж болзошгүй гол нөлөөлөл

Алт агуулсан элс угаах үйл ажиллагаа явуулахад ус их хэмжээгээр хэрэглэнэ. Мөн ажилчдын унд ахуйн зориулалтаар ус хэрэглэнэ. “Монгол Ус” төрийн өмчит үйлдвэрийн газраас ус ашиглуулах дүгнэлтээр 2022 онд баяжуулах үйлдвэрийн технологийн хэрэгцээ, унд ахуйн усан хангамж зэрэгт нийт 981.75 мян.м³ ус хэрэглэхээр байна.

Хүснэгт 2. Уурхайн усны хэрэглээ

Усны хэрэглээний төрөл		Хэмжих нэгж	2022 он
Төлбөр тооцох усны хэрэглээ	Ашигт малтмал олборлох, баяжуулахад шүүрлийн усыг шавхан зайлуулахад газрын доорх ус	м ³	123,618.22
	Нийт жилийн усны хэрэгцээ	м ³	123,618.22
Төлбөр тооцохгүй	Унд ахуйн ус	м ³	981.75

Алтны уурхайнуудад ашиглаж байгаа тунгаагуур нь төдийлөн техникийн шаардлага хангадаггүй, ихэвчлэн хэврэг байдаг бөгөөд тунгаагуурт ирж байгаа ус үерийн усаар угаагдан тунгаагуураас шууд гадаргын ус руу урсан орох тохиолдол их байдаг. Мөн алтны компаниуд усыг үр ашиггүй зарцуулж, усны нөөцийн хэмжээг бууруулж, усны чанарыг доройтуулж усан орчинд ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэг. Болзошгүй нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон эх үүсвэр, шалтгааны улмаас, түүнээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тохиолдолд гадаргын болон гүний ус бохирдож нөөц хорогдож болзошгүй. Алт элс угаах үйл ажиллагаа явуулж буй орчин нь түр зуурын урсгалтай гол горхитой.



Төслийн үйл ажиллагааны үед гадаргын болон газрын доорхи усны нөөц, горим түүний чанарт гол сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй байна. Иймд байгаль орчны менежментийн зорилго нь усны нөөцийг хамгаалах асуудал юм.

Машин механизмын зүй бус ашиглалтаас шатах тослох материал асгах эсвэл алдагдсан нөхцөлд хөрс ургамлын бүрхэвчид сөргөөр нөлөөлж улмаар хөрсөнд нэвчин гадаргын болон гүний усыг бохирдуулж болзошгүй. Төслийн талбайд хэд хэдэн хуурай сайр байгаа нөхцөлд аадар борооны үед усжин үер буух нөхцөлтэй. Ус шүүрэлт болон түүний чанар, нөөцийг байнгийн хянаж байх мониторингийн сайжруулснаар газрын гадаргын болон гүний усыг бохирдуулах магадлалыг бууруулах боломжтой.

Усыг зохистой ашиглах менежмент нь энэ төсөл хэрэгжихтэй холбоотой усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хязгаарлах юм. Усны нөөц, чанарыг хамгаалах зорилгоор доорхи ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Усыг ариг гамтай хэрэглэх
- Суваг, шуудуу байгуулан бороо, үерийн үед усыг зайлуулах
- Хог хаягдал, шатах тослох материалаар ус бохирдохоос хамгаалах
- Тухайн орон нутгийн малчдын усны чанар, хэрэглээнд нөлөөлөхгүй байх
- Усны эх үүсвэрт тоолуур суурилуулах



3.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас аллювийн намагт хөрс, хар хүрэн хөрс нөлөөлөлд өртөнө. Алтны шороон орд нь хэвтээ тогтоцтой, бага гүнтэй байдаг учир хөрс хуулалт, элс олборлолтонд өртөх талбайн хөрсөн бүрхэвч ухагдаж эвдрэн хөрсний механик бүтэц холилдоно.

Уурхайн тосгон, баяжуулах үйлдвэр, уурхайн дотоод зам гэх мэт барилга байгууламжийн улмаас хөрсний өнгөн хэсэг буюу ялзмагт давхарга устана. Ахуйн хог хаягдал, бохир усаар хөрс бохирдсоны улмаас газар доорх усыг бохирдуулах эрсдэлтэй. Уурхайн машин техникийн хөдөлгөөнөөр шороон зам үүсч хөрс эвдэрч талхлагдах, хөрсний гадарга хэт нягтрах, ховил гуу үүсгэх зэрэг сөрөг нөлөөллүүд үүсч, үүнээс улбаалан ургамлын төрөл зүйл цөөрөх, устах, бүрхэц багасч тоосжилт ихээр босох нөхцөл бүрдэнэ.

Уурхайн автомашинуудын шатах тослох материалын хэрэглээ болон хадгалалтын явцад нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд асгарсан тохиолдолд хөрс, ургамал бохирдож, газрын доорхи усанд нэвчиж, бохир уснаас уусан хүн болон мал, амьтны эрүүл мэндэд сөрөг нөлөөлж болзошгүй. Учир нь нефтийн бүтээгдэхүүнд төрөл бүрийн хортой хүнд металл болон органик бодис агуулагддаг. Мөн ахуйн хог хаягдал, бохир усаар хөрс бохирдох нөлөөтэй. Хог хаягдалд төрөл бүрийн бохирдуулагч бодисууд агуулагдаж байхаас гадна ахуйн бохир усанд халдварт өвчин үүсгэгч нян, бактери байдаг бөгөөд

3.4. Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.

Алт олборлох төслийн хүрээнд олборлолтонд өртөх, хөрсний овоолгод дарагдах, баяжуулах үйлдвэр, тосгон, уурхайн дотоод зам бусад барилга байгууламжийн улмаас үүссэн хөрсний эвдрэлийг дагаж ургамлан нөмрөгийн талхлагдал, доройтол үүснэ. Олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтонд ойролцоох талбайн ургамлан нөмрөг өртөж ургамлын фотосинтезийн процесс удааширч, ургамлын гадарга, навч гэмтсэн сөрөг нөлөөтэй.

Уурхайд ашиглаж байгаа машин механизмаас гарч буй дуу чимээнээс болж томоохон хөхтөн амьтад болон жижиг мэрэгч амьтад тээврийн хэрэгсэлд дайруулах, тоо толгой нь цөөрөх магадлалтай. Хөрс ухах, элс олборлох үндсэн үйл ажиллагаа нь хөрсөнд амьдрагч мэрэгч амьтад, мөлхөгчидийн амьдрах орчинг алдагдуулах сөрөг нөлөө үзүүлнэ. Хөрсний эвдрэл,



доройтол, орчны тоосжилтын улмаас ургамал идэшт амьтдын тоо толгой буурахад нөлөөлж болзошгүй.

Уурхайн автомашинуудын шатах тослох материалын хэрэглээ болон хадгалалтын явцад нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд асгарсан тохиолдолд хөрс, ургамал бохирдож, газрын доорхи усанд нэвчиж, бохир уснаас уусан хүн болон мал, амьтны эрүүл мэндэд сөрөг нөлөөлж болзошгүй. Учир нь нефтийн бүтээгдэхүүнд төрөл бүрийн хортой хүнд металл болон органик бодис агуулагддаг. Мөн ахуйн хог хаягдал, бохир усаар хөрс бохирдох нөлөөтэй.

Хог хаягдалд төрөл бүрийн бохирдуулагч бодисууд агуулагдаж байхаас гадна ахуйн бохир усанд халдварт өвчин үүсгэгч нян, бактери байдаг бөгөөд бохир усаар хөрс бохирдож, улмаар мал амьтан, газрын доорхи ус бохирдуулах эрсдэлтэй..



ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

4.1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“АУМ АЛТ” ХХК-нь 2016 оноос тус талбайд жил бүр нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэж ирсэн бөгөөд байгаль орчинд нэмж гарах сөрөг нөлөөллийг багасгах, хөрс хуулалт, газрын эвдрэл болон, олборлолтын зохистой харьцааг тогтоож, орчны хяналт шинжилгээний чиглэлээр сорьц авах, уурхайн орчинд үүсэж буй тоосжилтыг багасгах, гарч болох хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх, саармагжуулах зэрэг чиглэлээр арга хэмжээ авч, техникийн нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулан ажиллалаа. 2022 оны БОМТ-ний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг товчхон дурдвал:

- Угаах төхөөрөмжөөс гарч байгаа үйлдвэрийн хаягдал усыг эргэлтийн усан санд хуримтлуулан байгалийн аясаар тунгаан эргүүлэн ашиглав.
- Уурхайн гадаад болон дотоод тээвэрлэлтэнд зориулагдсан замыг зөвхөн нэг маршрутаар хийсэн.
- Хуурайшилт тоосжилт ихтэй үед уурхайн технологийн процессын дагуу ухаж ачих, тээвэрлэх, овоолго хийх явцад тоосжилтыг багасгах замаар орчны агаарын чанарыг хамгаалж тээвэрлэлт хийх зам талбай болон овоолгыг усаар шүршин тоосжилтыг бууруулсан.
- Уурхайд ажиллах машин, техникүүдийн засвар үйлчилгээг тогтмол хугацаанд хийж, урсгал засварыг зөвхөн тусгайлан заасан талбайд хийсэн.
- Орчны хяналт шинжилгээнүүдийг тогтоосон цэгүүдээс тогтмол хугацаанд авч шинжлүүлж гарсан үр дүнг харгалзан арга хэмжээнүүдийг авлаа.
- Хог хаягдлыг бууруулахын зорилгоор уурхайд аль болох нэг удаагийн хэрэглээг багасгаж, энгийн хог хаягдлын түр хуримтлуулах бункер байршуулсан, энгийн хог хаягдлыг бүртгэх маягт бүртгүүлсэн, сумтай хог хаягдлын гэрээ байгуулсан, ашигласан тос маслыг хуримтлуулан, нийлүүлэхээр “ХАЙ БИ ОЙЛ” ХК-тай гэрээ байгуулсан.
- Унд ахуйн хэрэглээнд зориулж, зохих журмын дагуу зөвшөөрөл авч, мэргэжлийн байгууллага “Баянговь ус” ХХК-аар гаргуулсан. Усны эх үүсвэрт тоолуур суурилуулав.

Хүснэгт 3. Агаарын бохирдлыг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт	Зардал /сая.төг/
1	Техник, тоног төхөөрөмжийн засвар тохиргоо, битүүмжлэл болон техникийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийв.	Уурхайн дарга, Сэлбэгийн нярав, БО-ны ажилтан	Агаар шүүгч-12, маслын шүүр 36, түлшний шүүр- 54 болон бусад засвар үйлчилгээг хийв	7,5
2	Мөн агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл, физик бохирдлыг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хийлгүүлэв.	БО-ны ажилтан	Өвөрхангай УЦОШГ 1-3 давталтаар /карьер, кемп, гадаад зам/ 1 удаа шинжилгээ авсан.	ОХШХ-т тусгав



3	Шинээр байгуулах овоолго, тээврийн хэрэгсэлийн дотоод зам талбайг тухрай бүрт нь усалж чийгшүүлэв.	Ерөнхий инженер	Энэ жил харьцангуй бороо хур ихтэй, хур тунадастай тоосжилт багатай тул шаардлагатай үед усалгааг хийж, бүртгэл хөтлөв.	2.5
4	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлөв	Уурхайн дарга	Бульдозер 2 ш, утгуурт ачигч 1ш, экскаватор 2 ш, автосамосвал 3 ш, бусад машин механизм.	1.33
Нийт төг				11.3

4.1.1. Агаарт чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Автомашин хөдөлгөөнөөр сул хөрстэй хөрсний өнгөн үе давхарга элэгдэж тоос босох нөхцөл бүрддэг. Өлтийн талбайд гадаад тээврийн зам болон дотоод тээврийн зам байна. Гадаад тээврийн замын хувьд Өлтийн уурхайг ашиглаж эхлэх /1993/ оноос эхлэн зурвас зам үүсч, жил бүр замыг засч сэлбэх, хучилт хийх, тоосжилтоос сэргийлэх усжилт хийж ирсэн.

Уурхайн дотоод тээврийн хувьд замын рейс аль болох богино байх чиглэлийг сонгон авч, замыг засч сайжруулан, уурхайн гадаад дотоод замын тоосыг дарж, чийгшүүлснээр агаарт дэгдэх тоосны хэмжээ, салхиар зөөгдөх тоосыг багасгаж, бүртгэл хөтлөв.

Хүнд машин механизмын хөдөлгүүрийн дутуу шаталтаас үүсэх хорт хийг багасгахын тулд техникийн үзлэг үйлчилгээг тогтмол хийж, техникийг ашиглахаас бусад үед асаалттай орхихгүй байх, утааны хэмжээг стандарт хэмжээнд байлгах арга хэмжээнүүдийг авсан.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд 2022 онд 11.3 сая төгрөг зарцуулсан байна.

4.1.2. Газрын гадарга, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Уулын ажлыг зохих журам, стандартын дагуу явуулж, хөрс, ургамал, газрын хэвлийн элэгдэл, эвдрэлийг хамгийн бага байлгахын тулд зөвхөн нөөц тогтоогдсон хил хүрээнд олборлолтыг явуулж, олборлолтонд өртсөн талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг мэргэжлийн арга зүйн зөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэв.

Уурхайн үйл ажиллагааны улмаас газрын гадаргуугийн төрх байдал өөрчлөгдөж ашиглагдсан хоосон орон зай үүсэж, хөрс чулуулгийн овоолго бий болох ба овоолгыг налуу газар байрлуулбал борооны усанд амархан элэгдэж угаагдан эвдэрч, салхиар хийсч зөөгдөх зэрэг сөрөг үр дагаврыг бий болохыг анхаарч овоолгыг зөв талбайд байгуулах, овоолгыг тойруулан үерээс хамгаалах суваг шуудуу татав.

Уурхайн нүх болон ухашид хүн мал, амьтан унаж бэртэхээс сэргийлж тэмдэгжүүлэлт хийсэн.

Тос, тослох материал, масло асгаран хөрсөн бүрхэвчийг бохирдуулахаас урьдчилан сэргийлж элс болон нарийн гааль, шламыг зэрэг материалуудыг бэлдэж бэлэн байдалд



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УЯНГА СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ ӨЛТИЙН ДЭЭД ХЭСГИЙН АЛТНЫ
ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

оруулав. Галын аюулаас урьдчилан сэргийлж галын булангуудыг байгуулж өгсөн. Газар хөрсөнд үзүүлэх нөлөөллийг бууруулахад нийт 90,7 сая төгрөг зарцуулсан байна. ТӨҮГ-аар микробиологийн шинжилгээ хийлгэсэн.

Хүснэгт 4.

Хүснэгт 4. Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажлууд

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт	Зардал /сая.төг/
1	Газар ашиглах гэрээг Уянга сумын ЗДТГ-тай байгуулж, төлбөр төлөв.	Компанийн захирал	Газрын төлбөр төлөв	88.7
2.	Химийн бодисын хадгалалтыг, ашиглалтыг зөв явуулсан	Ерөнхий механик	Техникийн тос, будаг, лак, шингэлэгч, цавуу зэрэг химийн гаралтай бодисуудыг тусгай байгууламжид зохих хэмжээгээр хураав.	0,3
3	Уурхайн олборлолт тээвэрлэлтийн зам засах	Уулын инженер	Уурхайн олборлолтын явцад гадаад дотоод замыг шаардлагатай үед засаж сайжруулав	Дотоод зардлаар
4	40 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийв. 4 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийв.	БО-ны ажилтан	MNS Стандартын дагуу 40 га-д эвдэгдсэн талбайг нөхөн дүүргэлт хийж, тэгшлэн, техникийн нөхөн сэргээлт хийсэн. 4 га талбайд нийт 450 кг олон наст ургамлын үрийг /царгас, саман ерхөг, хошоон, судан өвс/ үрлэгч машинаар тарин хашаажууллаа.	Нөхөн сэргээлтийн зардал
5	Шатах тослох материалын алдагдлыг тогтмол хянаж, бүртгэл хөтлөв	Түлшний нярав, БОТЛ	Хаягдал тос маслыг нийлүүлэх зорилгоор “ХАЙ БИ ОЙЛ” ХК-тай гэрээ байгуулсан. ШТМ-ын асгалтыг тухай бүртгэл хөтлөв.	0,3
6	Хөрсний шинжилгээний төлбөр төлсөн	БО-ны ажилтан	Хөрсний агрохими, хүнд металл, бактерийн шинжилгээнүүдийг 2-5 цэгт жилд 2 удаа шинжилгээ хийв.	ОХШХ-т тусгав
7	Шатах тослох материалын алдагдлаас сэргийлэх арга хэмжээ авав	Түлшний нярав, БОТЛ	Шатах тослох материал хадгалах сав, авто засвар хийгдэх талбайн доор хамгаалалтын суурь хучилт хийв.	1,0
8	Ахуйгаас гарсан шингэн хатуу хог хаягдал алдагдсанаас хөрс бохирдуулна.	БО-ны ажилтан	Уурхайн тосгоны өнгө үзэмжийг сайжруулж мод, бут тарих, цэцгийн мандал байгуулж зүлэгжүүлнэ.	0.4
Нийт зардал				90,7



Зураг 2. Кемпийн тохижилтын ажил хийгдсэн байдал



Зураг 3. ШТС-ийн орчмын түлш асгарсныг цэвэрлэсэн байдал



Зураг 4. Яамны дор асгасан шингэн, бохирдсон хөрсийг зайлуулж, шинээр хөрс хучсан байдал



Зураг 5. ШТС-ийн түгээх хэсэг болон автоцистерн зогсох талбайг хувив

4.1.3. Усан орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Мэргэжлийн байгууллагатай хамтран хаягдлын болон тунгаах нууруудын далангийн бат бэх байдлыг хангаж, шүүрэлт, нэвчилтээс хамгаалж ажиллав. MNS 5924:2008 "Нүхэн жорлон, бохир усны нүх"-ний ерөнхий шаардлага хангасан ажилчдын бие засах газрыг барив.

Ахуйн бохир ус, шатах тослох материал асгарснаас хөрс бохирдон улмаар газрын доорх ус бохирдох тул асгарсан, нэвчсэн тохиолдолд бохирдлыг даруй арилгаж, саармагжилтыг цаг алдалгүй хийв. Газрын доорх усны чанар нь MNS 0900:2005 стандартыг хангаж буйг хянах зорилгоор ундны ус, ундны усны савны усанд микробиологийн болон химийн ерөнхий шинжилгээг тогтмол хийлгэв.

Усны нөөц, хомсдлыг бууруулах зорилгоор технологид ашигласан бохир усыг MNS 4943:2015 стандартад хүргэн цэвэрлэн, дахин ашиглах цэвэрлэсэн ус, технологийн ерөнхий шаардлага /MNS 6734:2018/-д нийцсэн усыг технологийн усны хэрэгцээнд болон зам усалгаанд ашиглах боломжийг мэргэжлийн компаниас зөвлөгөө авч мөрдлөгө болгон ажилласан.



Зураг 6. Тунгаах нуурын ерөнхий байдал

Хүснэгт 5. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажлууд

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт	Зардал /сая.төг/
1	“Монгол ус” ТӨҮГ-аар ус ашиглуулах дүгнэлтээ гаргуулж, Онги голын сав газрын захиргаатай /ОГСГЗ/ гэрээ байгуулан гэрээний дагуу ус ашиглах төлбөрөө төлнө.	Компанийн захирал	2022.05.19-ны өдөр Монгол ус ТӨҮГ-аар дүгнэлт гаргуулж, Онги голын СГЗ-аар ус ашиглах гэрээ байгуулж, гэрээний дагуу усны төлбөрөө төлөв.	96,422,211
2	Үерийн ус орохоос сэргийлэх, уурхайн далан сэтэрч эргэлтийн ус алдахаас хамгаалах	Ерөнхий инженер		Ү/а-ны зардал
3	Ахуйн бохир усыг хөрсөнд нэвчихгүй байхад анхаарч тогтмол хугацаанд бохирыг соруулах, ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээ авна	БО-ны ажилтан, Аж ахуйн ажилтан		1,0
5	Усны чанарт хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэв	БО-ны ажилтан	Өвөрхангай УЦУОШГ-тай гэрээ байгуулсан. Нийт 2-3 цэгээс нийт 6 удаа дээж авав.	ОХШХ-т тусгав
	Нийт зардал			97,4



4.1.4. Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах арга хэмжээ

- Автомашин, техникийн хөл хөдөлгөөнөөр олон салаа зам гаргахаас зайлсхийж тогтсон нэг маршрутаар зорчиж, технологийн замын дүрмийг баримталж ажиллав.
- Уурхайн тосгоны хашаанд мод, бут, цэцэг тарьж тохижуулав.
- Туслах аж ахуйн хөгжүүлснээр өдөр тутмын хоол хүнсний хаягдлыг ил задгай хаяхгүй байснаар зэрлэг амьтад, шувууд муудсан хоол идэх, өвчлөхөөс сэргийлж чадлаа.
- Төслийн үйл ажиллагаа, олборлолтын ажлын үед үүсэх дуу чимээний хэмжээг бага түвшинд байлгах талаар анхаарч дуу чимээ бага гаргадаг, техникийн үзүүлэлт сайтай тоног төхөөрөмжүүд ашиглав.
- Биологийн төрөл зүйл, тоо толгойг хамгаалах үүднээс орон нутгийн захиргаа, байгаль орчны алба, сумын байгаль орчны мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах, санал солилцох, шаардлагатай тохиолдолд тэдгээрт туслалцаа үзүүлэв.

Хүснэгт 6. Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах ажлууд

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт	Зардал /сая.төг/
1	Эвдэгдсэн газрыг нөхөн сэргээн дүүргэн тэгшлэв.	Ерөнхий инженерБ О ажилтан	“Бага Өлт” 40 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	Дотоод зардал
	Биологийн аргаар нөхөн сэргээлтийн талбайд бэлчээрийн идэмжит ургамлыг тарив.	БО ажилтан	4 га талбайд саман ерхөг, царгас, хошоон, судан өвс тариалах	Нөхөн сэргээлтийн зардал
2	Хууль бус хулгайн анг таслан зогсооход анхаарч ажилласан.	БО ажилтан	Төслийн талбайн ойролцоох айлуудад сурталчилж, сануулах	0,2
	Холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулах сургалт явуулна.	БО ажилтан, Уурхайн дарга	Төслийн талбайн ойролцоох айлуудад сурталчилж, сануулах	0,2
3	Тоосжилтыг бууруулах, шаардлагатай үед дотоод тээврийн замыг услах арга хэмжээ авсан	БО ажилтан	Энэ жил хур бороо ихтэй байсан учир зам усалгаа бага хийгдсэн. Хуурайшилт ихтэй өдрүүдэд усалгаа хийгдсэн.	2.6
4	Гал түймрийн аюулаас хамгаалж, гал унтраах багаж хэрэгсэл болон галын дохиолол хотхонд байрлуулав.	Уурхайн дарга, нярав	Галын хорны бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж, шаардлагатай 5 газарт ГК болон утаа мэдрэгч дохиодод суурилуулав.	10,0
Нийт				13,0



Зураг 7. Биологийн нөхөн сэргээлт ерөнхий бйадал



Зураг 8. Гал унтраах хэрэгсэл



Зураг 9. Галын дохиолол суурилуулж



4.2.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Өлтийн бүлэг шороон ордод 1993 оноос “Эрэл” ХХК олборлолтын үйл ажиллагааг эхлүүлж, 2007 оноос “АУМ” ХХК үйл ажиллагааг үргэлжлүүлэн 2016 оны 04 сард манай компани тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авсан. Манай компани 2012-2021 оны хооронд нөхөн сэргээлтийн ажлыг MNS 5917:2008 стандартын дагуу гүйцэтгэж ирсэн.

Шимт хөрс хучсан талбайн 4 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийсэн бөгөөд “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага” “MNS 5918:2008” стандартыг баримталлаа.

